


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

11.30 - 12.04



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн гол индексүүд түүхэн дээд ханшиндаа хүрч өсөлттэй хаагдсан байна. OPEC болон бусад томоохон газрын тос олборлогч орнууд бууруулсан байгаа нийлүүлэлтийг ирэх онд өмнө нь тохиролцосон байснаас илүү алгуур нэмэгдүүлэх болсонтой холбоотой эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байсан бол ус, цахилгаан, дулааны салбарын компаниуд хамгийн их бууралттай байлаа. Даваа гараг буюу 11-р сарын сүүлийн өдрийн арилжааны дараа Dow Jones индекс 1987 оноос хойших хамгийн их сарын өсөлтийг үзүүлсэн бол small-cap Russell 2000 индекс 1978 он буюу анх үүссэнээсээ хойш хамгийн их сарын өсөлтийг үзүүлжээ.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт холимог үзүүлэлттэй байлаа. Европын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэгч STOXX Europe 600 индекс бага хэмжээгээр буюу 0.21%-аар өссөн ч бусад томоохон индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. CAC 40 индекс 0.20%-аар өссөн ч DAX индекс 0.28%-аар, FTSE MIB индекс 0.78%-аар буурсан байна. Их Британи улс Pfizer болон BioNTech компаниудын хөгжүүлсэн коронавирусын эсрэг вакцинд хэрэглэх зөвшөөрөл олгосноор FTSE 100 индекс 2.87%-аар өсөн сүүлийн 9 сарын дээд түвшиндээ хүржээ.

АНУ-аас эдийн засгийг дэмжих нэмэлт арга хэмжээ авах хүлээлт болон вакцинтай холбоотой эерэг мэдээнээс үүдэн Евро бүсийн голлох бондуудын өгөөж энэ долоо хоногт өсөлттэй байсан ч үйлчилгээний салбарын үйл ажиллагаа хязгаарлагдсантай холбоотой Евро бүсийн худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) өмнөх сараас буурсан нь өгөөжийн өсөлт хязгаарлагдмал байхад нөлөөлжээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. Nikkei 225 индекс 107 нэгжээр буюу 0.40%-аар өсөж 26,751.24 нэгж хүрсэн нь оны эхэн үетэй харьцуулахад 13.1%-аар өссөн үзүүлэлт болсон байна. Харин Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд бага зэрэг бууралттай байсан байна. Иений ам.доллартой харьцах ханш тогтвортой буюу Баасан гараг гэхэд ам.доллар 104 иен хавьцаа арилжаалагдаж байв.

Япон улсын аж үйлдвэрлэлийн хэмжээ 10-р сард хүлээлтээс илүү буюу 3.8%-аар өссөн байна. Энэхүү өсөлт нь аж үйлдвэрийн машин механизм, автомашин, цахилгаан бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ өссөнтэй холбоотой байлаа.

БНХАУ: Эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг гарч байгаатай холбоотой энэ долоо хоногт БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин өсөлттэй байлаа. CSI 300 индекс 1.7%-аар, Shanghai Composite индекс 1.1%-аар тус тус өссөн байна. БНХАУ-ын гадаад зах зээлд гаргасан 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 3 нэгжээр бууран 3.33% хүрсэн байна. Харин ам.долларын эсрэг юанийн ханш 0.5%-аар чангарч нэг ам.доллар 6.53 юань хүрсэн байна.

АНУ-аас БНХАУ-ын 4 компанид хориг тавьсан ч гадаадын хөрөнгө оруулагчид БНХАУ-ын зах зээлийг сонирхсоор байна. Үүний том илрэл нь 11-р сард БНХАУ-ын бонд, ялангуяа БНХАУ-ын ЗГҮЦ-ны эзэмшлийн ихээхэн хэсэг гадаад хөрөнгө оруулагчдад байгаа явдал юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,658.44	0.62% ▲
Dow Jones	АНУ	30,218.26	1.03% ▲
S&P 500	АНУ	3,699.12	1.67% ▲
Nasdaq	АНУ	12,464.23	2.12% ▲
S&P/TSX	Канад	17,520.97	0.72% ▲
FTSE 100	Их Британи	6,550.23	2.87% ▲
S&P/ASX 200	Австрали	6,634.10	0.50% ▲
Nikkei 225	Япон	26,751.24	0.40% ▲
Hang Seng	Хонг Конг	26,835.92	0.06% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	3.44%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.13%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.01%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	1.39%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.08%
DBM' 2023	USD	7.250%	4.23%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	9.85%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	3.80%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.152	0.00 ▼
Libor 3M	0.226	0.00 ▲
Libor 6M	0.256	0.00 ▼
Libor 1YR	0.337	0.01 ▲
US 2YR Bond	0.149	0.00 ▼
US 3YR Bond	0.205	0.01 ▲
US 5YR Bond	0.412	0.05 ▲
US 10YR Bond	0.951	0.12 ▲

Валютын ханш	2020.12.04	Өөрчлөлт
USD	2,849.26	-0.01% ▼
CNY	436.13	0.74% ▲
EUR	3,461.85	1.85% ▲
RUB	38.36	2.13% ▲
KRW	2.63	1.94% ▲
JPY	27.42	0.15% ▲
CAD	2,215.43	1.15% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,838.86	2.86% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	24.19	7.14% ▲
Зэс	USD/lb.	352.45	3.13% ▲
Нүүрс	USD/MT	75.15	9.31% ▲
WTI газрын тос	USD/bbl.	46.26	1.60% ▲
Brent газрын тос	USD/bbl.	49.25	2.22% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.X	2.40%
Бодлогын хүү	2020.X	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.X	7.67%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.X	10.65%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.X	3.83%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.X	16.82%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.X	10.47%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 92.6 сая төгрөгийн 673,180 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Техник импорт” /MSE: TEX/ компанийн хувьцаа 26.67%-аар буюу хамгийн ихээр өсөж 8,740.00 төгрөг хүрч хаагдсан бол “Монгол савхи” /MSE: UYN/ компанийн хувьцаа 10.53%-аар буурч 425.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 9.2 сая төгрөгийн 90 ширхэг үнэт цаас арилжаалагдав.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

12-р сарын 4-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,606.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,658.44 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.78%-аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	90	9,180,000	102,000	102,000	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	101.8	
Зах зээлийн үнэлгээ	2,606,301.3	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,658.44	0.78% ▲
MSE I индекс	8,117.58	1.23% ▲
MSE II индекс	7,356.71	-0.69% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
АПУ	34,233	19,755,035
Эрдэнэ ресурс девелопмент корп	13,266	11,268,246
Мандал даатгал	215,278	10,335,122
Таван толгой	1,331	8,114,585
Үндэсний хувьчлалын сан	58,786	6,206,258

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Техник импорт	8,740.00	26.67% ▲
Адуун чулуун	978.00	14.97% ▲
Тандэм инвест ББСБ	18.50	14.91% ▲
Бөөний худалдаа	515.00	14.44% ▲
Женко тур бюро	89.51	10.37% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол савхи	425.00	-10.53% ▼
Шивээ овоо	1,800.00	-10.00% ▼
БиДиСек	791.50	-8.07% ▼
Монголын цахилгаан холбоо	351.00	-7.87% ▼
Атар-өргөө	65,000.00	-7.80% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	57,608,067
БиДиСек	44,758,888
Стандарт Инвестмент	24,367,510
Апекс Капитал	21,240,722
Ти Ди Би Капитал	14,523,816

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	578.63	615,767.37
Таван толгой	6,075.00	319,941.09
МИК холдинг	11,500.00	238,157.18
Инвекор ББСБ	2,919.00	209,373.79
Говь	192.00	149,781.60

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Тандэм инвэст ББСБ” /MSE: VIK/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр.

“Тандэм инвэст ББСБ” /MSE: VIK/ ХК-ийн 2020 оны 11-р сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнд:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх үүднээс Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн нэг бүр нь 19 төгрөгийн үнэ бүхий 134,953,581 ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргах.
2. Компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байх.

3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор компанийн нийт зарласан хувьцаа болох 3,003,866,050 ширхэг хувьцаанаас зах зээлийн нөхцөл байдалд уялдуулан үе шаттайгаар хөрөнгийн зах зээлээс нээлттэй болон хаалттай хүрээнд хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх.
4. Нэмэлт хувьцаа санал болгох үнэ, тоо ширхэг, гаргах хэлбэр, хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох.
5. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбоотой компанийн хөрөнгө нэмэгдэж, гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт орох тул өөрчлөлтийг компанийн дүрэмд тусган, холбогдох газруудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б. Золжаргал)-д үүрэг болгох шийдвэрүүд гарсан байна.

БУСАД МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаан боллоо.

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит 22-р хуралдаан цахим хэлбэрээр өнөөдөр хуралдаж нийт 14 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Үүнд, нэр бүхий дөрвөн иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохын зэрэгцээ банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус бүр нэг компанид нэмж олгохоор шийдвэрлэсэн бол таван хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус сунгалаа.

Харин энэ удаагийн хуралдаанаар нэг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг багасгасантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо. Мөн Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газраас хоёр компанийн үнэт цаасны зах зээлд брокерийн үйл ажиллагаа болон брокер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг, нэг компанийн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх, нэр бүхий хоёр компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус түдгэлзүүлэх тухай санал оруулсныг эцэслэн шийдвэрлэсэн юм.

Хуралдааны төгсгөлд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан гамшгаас хамгаалах бэлэн байдал буюу цар тахлын энэ үед Хорооны шуурхай штабын баг буюу нийт 11 албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд ажилтан, албан хаагчид цахим хэлбэрээр ажлаа явуулахын зэрэгцээ иргэд, зохицуулалтын байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг цахим хаяг, утсаар хүлээн авч шуурхай, цаг тухай бүрт нь шийдвэрлэж ажиллаж байгаа талаарх мэдээллийг

Хорооны гишүүдэд өгсөн юм. Мөн тэрбээр энэ үеэр УИХ-аас баталсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон 2020 оны 11-р сарын 18-ны Засгийн газрын 183 тоот тогтоолын дагуу банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршооны зээлийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгжүүдэд зээлийн дарамт үүсгэхгүй, төлбөрийн чадварт нь нийцсэн байдлаар зээлийн төлбөрийг сунгах чиглэлээр тодорхой авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар танилцуулахын зэрэгцээ Хөрөнгийн биржийн арилжаа цахим горимоор хэвийн явагдаж талаар мэдээллээ. Тухайлбал, хэдийгээр энэ өдрүүдэд хөрөнгийн зах зээлийн арилжааны хэмжээ багассан ч энэ сарын 11-23-ны өдрүүдэд 680 гаруй сая төгрөгийн үнэ бүхий үнэт цаасны арилжаа хийгдсэн талаар онцолсон. Цаашилбал, даатгалын компаниуд цар тахлын үед цахим горимоор үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дээрх өдрийн байдлаар нийтдээ 1,775 даатгалын тохиолдол бүртгэгдэж, 699 тохиолдолын 274.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон талаар мэдээллээ.

Дашрамд сонирхуулахад, Хорооны ээлжит хуралдаан энэ жил нийтдээ 24 удаа хуралдахаас өнөөдрийн байдлаар 22 удаад хуралдаад байна. Тодруулбал, зохицуулалттай этгээдүүдийнхээ үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах, зохицуулах зорилгоор Хорооноос хуралдааныг холбогдох журамд заасан хуваарийн дагуу тогтмол хуралдуулж ажиллаж ирлээ. Цар тахлын энэ үед ч салбартай холбоотой бодлого шийдвэрийг шуурхай тасалдалгүй гаргах, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг цаг тухай бүрт нь хурдан шийдвэрлэх зорилгоор хуралдааныг цахим хэлбэрээр хуралдуулж ажиллаж байна.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

БНХАУ Ази, Номхон далайн бүс нутгийн компаниудын хувьд тэргүүлэх гадаад зах зээл болсныг "HSBC"-ийн судалгааны дүн харуулж байна. Энэ үзүүлэлтээр АНУ-ыг ардаа орхиж нэгдүгээрт бичигдэж эхэлжээ.

Судалгаанд хамрагдсан компаниудын 29 хувь нь "Худалдааны хамгийн том түнш нь БНХАУ" гэж хариулсан байна. Харин 28 хувь нь АНУ-ыг нэрлэжээ. Жагсаалтын дараалал ийнхүү өөрчлөгдөхөд цар тахал болон "Худалдааны дайн" нөлөөлсөн гэж тайлбарлаж байна. "АНУ-ын протекционист бодлогоо тэлж байгаатай зэрэгцэн Азийн бүс нутаг дахь дотоод худалдаа эрчимжиж байна" гэж "HSBC" онцолжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Банкуудад репо арилжаагаар урт хугацаатай санхүүжилт олголоо.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 оны 9-р сарын 14-ний өдрийн 5-р тогтоол, 11-р сарын 23-ны өдрийн 6-р тогтоолоор уул уурхайн бус экспортын болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжихэд зориулсан урт хугацаат санхүүжилт олгох зорилгоор 2 жилийн хугацаатай репо арилжааг зарлахаар шийдвэрлэсэн. Улмаар 2020 оны 4-р улиралд нийт 230 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн бөгөөд Монголбанк 2020 оны 11-р сарын 30-ны өдөр эхний урт хугацаатай репо арилжааг зарлаж, банкуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 175 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хаан, Хас, Капитрон, Төрийн, Тээвэр хөгжил, Богд банкуудад олголоо.

Банкууд тус санхүүжилтийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11-р сарын 25-ны өдрийн А-426-р тушаалаар баталсан зээлийн шалгуурыг хангаж буй уул уурхайн бус экспортын салбар болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт төгрөгөөр олгосон хэвийн зээлийг дахин санхүүжүүлэх, шинээр зээл олгоход зориулах юм.

Ингэснээр шалгуур хангаж буй уул уурхайн бус экспортын салбар болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь дээр дурдсан харилцагч банкиндаа хүсэлт гаргах, зээлийн хүүг 10.5%-аас хэтрэхгүй байхаар бууруулах, үндсэн төлбөрөөс 6 сараас багагүй хугацаанд чөлөөлөгдөх боломжтой боллоо.

Эх сурвалж: .Монголбанк

23 арга хэмжээний хүрээнд гол хуулийн төслүүдээ УИХ-аар хэлэлцүүлэхээ засгийн газар мэдэгдэв.

Засгийн газар 12-р сарын 3-ны өдрөөс сайжруулсан шахмал түлшийг 50% хямдралтай үнээр буюу нэг тонныг нь 75 мянган төгрөгөөр худалдахаар шийдвэрлэлээ.

Энэхүү арга хэмжээ 2021 оны 4-р сарын нэгний өдөр хүртэл үргэлжлэх бөгөөд гэр хорооллын 220 мянган өрх хамрагдах юм байна.

Мөн Гашуунсухайт, Шивээхүрэн, Цагааннуур, Эрээнцав, Замын-Үүд боомтод Засгийн газрын ажлын хэсэг хяналт шалгалтыг эрс сайжруулах чиглэлээр ажиллаж байгааг Шадар сайд Я.Содбаатар мэдээллээ.

Үүнээс өмнө Засгийн газар эдийн засгийг дэмжих 23 арга хэмжээ авахаар зарласан юм. Энэ хүрээнд түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжүүдэд түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлэн эдлүүлэх, мөн хугацаандаа төлөөгүй татварын алданги, торгуулийг 2021 оны 7-р сарын нэгний өдөр хүртэл чөлөөлөхтэй холбоотой хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлнэ гэж мэдэгдээд байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

Ирэх оны төсөвт тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг УИХ дэмжсэнгүй.

2021 оны Төсвийн тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хэлэлцэж дэмжсэнгүй. Хоригийн хүрээнд өрх бүрд нэг сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсруулах санал гаргасан юм.

Энэ нь эрэлтийг дэмжих замаар аж ахуйн нэгжүүдэд, дотоодын үйлдвэрлэгчдэд 900 гаруй тэрбум төгрөгийн дэмжлэг болно гэж үзжээ. Мөн төсвийн нийт зардлыг 20 хувиар хэмнэж, хүндрэл бэрхшээлийг даван туулахад зориулсан Эрсдэлийн сан байгуулах шаардлагатай гэсэн санал тусгаад байсан юм.

Ирэх оны төсвийг цар тахал дотоодод тархахаас өмнө боловсруулсан бөгөөд мөн "коронавирус"-ийн халдвар тархаад удаагүй байхад хуулийн хугацаанд нь амжиж батлуулсан юм. Хэдий тийм боловч эрх баригчид ирэх оны төсвийг тодотгож магадгүй байгаа ч одоогоор тодотголыг боловсруулж, УИХ-д өргөн бариагүй байна.

Ирэх онд төсвийн алдагдал 2.2 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувьтай тэнцэхээр батлагдсан юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанкны худалдан авсан үнэт металл 21 тоннд хүрэв.

Монголбанк 2020 оны 11-р сард 1.7 тонн үнэт металл худалдан авлаа. Он гарснаас хойш өссөн дүнгээр нийт 21 тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 6.5 тонноор өсөөд байгаа бөгөөд нийт худалдан авсан үнэт металлын 19.3 тонн нь алт, 1.7 тонн нь цагаан мөнгө юм.

Орон нутаг дахь үнэт металлын худалдан авалтын хувьд мөн сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 106.5 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 98.7 кг авч, он гарснаар нийт дүн 1.8 тоннд хүрээд байна.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 11-р сард 170,810.51 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк

АНУ-ын нүүрс олборлогч 2 компани дампуурлын хамгаалалт хүслээ.

АНУ-ын нүүрсний хоёр компани дампуурлын хамгаалалт хүсэж, хүсэлт гаргасан байна. АНУ-ын нүүрсний гарц II улиралд сүүлийн 50 жилийн хамгийн бага түвшинд хүрч буурчээ. Байгалийн хий, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байгаа аж.

Үүнээс гадна энэ онд АНУ-д цар тахлаас үүдэлтэй хөл хорионууд ээлж дараалан тавигдсанаар оффис, үйлдвэр, дэлгүүрүүдийн эрчим хүчний хэрэглээ эрс буурч, түүнийг дагаад нүүрсний эрэлт ч буурчээ. Энэ нь АНУ-ын нүүрс олборлогч компаниудад хүнд тусаж байна.

АНУ-ын нүүрс олборлогч хамгийн том компани болох "Peabody Energy" ижил төстэй асуудалтай тулгарч байгаагаа өнгөрсөн сард мэдэгдсэн юм. Мөн зах зээл сэргэхгүй бол дампуурлын хамгаалалт хүсэж магадгүй гэсэн байна. Ингэвэл таван жилийн дотор хоёр дахь тохиолдол болох ажээ.

Энэ удаад дампуурлын хамгаалалт хүссэн "Lighthouse Resources"-ийн өрийн хэмжээ 456 сая ам.доллар, "White Stallion"-ийнх 104 сая ам.доллар болсон байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

"Nord stream 2"-ийн бүтээн байгуулалт энэ 7 хоногоос үргэлжилнэ.

АНУ-ын хориогийг үл харгалзан энэ долоо хоногоос Балтын тэнгис дэх "Nord Stream 2" хийн хоолойн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх гэж байна. Нийт 9.5 тэрбум еврогийн хоолойгоор дамжуулж ОХУ-аас Германд байгалийн хий нийлүүлэх зорилготой.



Өнгөрсөн онд Дональд Трамп хоолойн бүтээн байгуулалтад оролцож буй компаниудад хориг тавьснаар барилгын ажил өнгөрсөн оны 12-р сард зогссон юм. Хэдий тийм боловч төслийн гол санхүүжүүлэгч нар санхүүжилтээ зогсоохоос татгалзсан байна. Түүнчлэн Германы Канцлер Ангела Меркель стратегийн ач холбогдолтой төслийг үргэлжлүүлэх ёстой гэсэн хатуу байр суурь илэрхийлж, бүтээн байгуулалтыг дэмжихээ илэрхийлсэн юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.